

С/28

БАТЛАВ.

ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН
ЗАХИРГААНЫ ДАРГА
/Я.БОЛДБААТАР/

Эхийн оны 6 дугаар сарын 06

БАТЛАВ.

"БАЯНГОЛ ЭКО ЗААМАР" ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

/Г.БАЯНЖАРГАЛ/

Эхийн оны 6 дугаар сарын 06

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

Дугаар 25

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

Монгол Улсын Усны тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу "Монгол-Ус" ТӨҮГ-ын захирлын "Дүгнэлт хүргүүлэх тухай" 2017 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 177 тоот, Туул голын сав газрын захиргааны даргын 2017 оны 6 дугаар сарын 06-ны өдрийн А-40 тоот тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж Туул голын сав газрын захиргааны Ус ашиглалтыг зохицуулах албаны уул уурхай, эрчим хүчиний ус ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн С.Сүхбат, Ус ашиглагчийг төлөөлж Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 15-р хороо, Туул гол гудамж, 73 байр, 28 тоотод байрлах, улсын бүртгэлийн 9011408108 тоот гэрчилгээ, 5906865 тоот регистрийн дугаартай "Баянгол Эко Заамар" ХХК-ийн захирал Г.Баянжаргал нар ус ашиглах талаар тохиролцож энэхүү гэрээг 2017 оныг дуустал байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт: Төв аймгийн Заамар сум, Булган аймгийн Бүрэгхангай сумын хилийг дамнан орших MV-000290 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй "Баянголын голдирлын алтны шороон орд"-ын үйлдвэрлэлийн технологийн хэрэгцээнд болон хун амын учд-ахуйн зориулалтаар усны нөөцийг ашиглана.

2.1.1. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын Сайдын 2014 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн A05 дугаар тушаалаар баталсан "Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тухайн, жилд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан Battlaх, тайллагнах журам"-ын 3.3-т заасны дагуу 2017 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биепалтийг хүлээж авах ажлын хэсэгт Туул голын сав газрын захиргаанаас төлөвлөх оролцуулж, дүнгэх хуудсийг баталгаажуулна.

2.2. Нийт ашиглах усны хэмжээ: 641'366 м³ ээлс угаахад зарцуулах ус 2'565'464 м³/жил

2.2.1. Үнд.ахуйд: 3348 м³/жил

2.2.2. Үйлдвэрлэлд нөхөн сэлбэлтээр ашиглах усны хэмжээ: 616'960 м³/жил

2.3. Усны чанар, наирлага: 2017 оны 7, 9 дүгээр саруудад Драгийн нуурнаас усны дээж авч итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэн, шинжилгээний дүнг Туул голын сав газрын захиргаанд ирүүлнэ.

2.4. Усны эх үүсээр:

2.4.1. Байршил: Технологийн хэрэгцээний усиг Драгийн олборлолтын явцад үүсэх шүүрэлтийн уснаас болон нэмэлтээр өмнө нь ашиглаж байсан хиймэл нуурнаас нөхөн сэлбэлтээр авч ашиглана. Өмнө нь ашиглаж байсан хиймэл нуурын байршил: N 48° 23' 53.4", E 104° 31' 27.1"

2.4.2. Берилэг байгууламж: Драгийн олборлолт явуулж буй хиймэл нуур нь 136'450 м³ залажуулттай 150 м x 100 м x 168 м x 108 м хэмжээтэй, дундаж түн 8 м. Мөн олборлолтын явцад Туул голоос болон өмнө нь ашиглаж байсан нуурнадаа 0-1.2 м түнтэй, 50-80 см өргөнтэй, 700 м урттай сувгаар дамжуулан Драгийн нуур нөхөн сэлбэдэг.

ЭХ СУРВАЛЖ: WWW.ILTODGEREE.MN

2.4.3. Тоног төхөөрөмжийн нэр, марк: ДМ250 маркийн драгтай.

2.4.4. Насосны хүчин чадал: Ус дамжуулах суваг нь өөрийн ургалаар Драгийн нуурыг нохон сэлбэдэг. Драг дотор 1260 м³/цаг хүчин чадалтай насос суурилагдсан.

2.5. Хаягдал усны хэмжээ, стандартын шаардлага: Хаягдал усыг хүрээлэн буй орчинд нийтлүүлэхдээ MNS 4943:2011 стандартын шаардлагыг мөрдлөг болгоно.

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бобисын хэмжээ:

2.7. Бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил, хүчин чадал, технологи, цэвэрлэх өргөгдлийн түвшин: Технологийн хаягдал усыг нууранд тунгааж, эргүүлэн ашиглача.

2.8. Усны эх үүсвэрэйг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зэрцүүлах хөрөнгийн хэмжээ: Усны тухай хуулийн 1 дүгээр бүлгийн 6 дугаар зүйлийн 6.2.3 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор ордын талбайд 2015 оны 12 дугаар сарын 07-ны өдөр суурилуулсан газрын доорх усны автомат түвшин хэмжигчийн мэдээллийг боловсруулахад 500.0 мянтэг зарцуулна.

2.9. Усны тоолуур: Технологийн усыг нөхөн сэлбэлтээр нэмэлтээр өөр бусад эх үүсвэрээс хангах тохиолдолд заавал усны тоолуур суурилуулна.

2.10. Ус ашигласны төлбөрийн хэмжээ:

2.10.1. Урьдчилсан байдлаар нөхөн сэлбэлтээр ашиглах 616'960 м³ усны нөөц ашигласны төлбөрт 147'200'487 /нэг зуун дечин долоон сая хоёр зуун мянга дөрвөн зуун наян долоо/ төгрөгийг Төв аймгийн Төрийн сан банкны 140000944 тоот дансанд төвлөрүүлнэ. Төлбөрийн 20 хувийг хоёрдугаар, 40 хувийг гуравдугаар, 40 хувийг дөрөвдүгээр улиралд төлнэ.

2.10.2. Байгалийн нөхн ашигласны төлбөрийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт заасны дагуу усны төлбөрийг төвлөрүүлэхдээ тоолуурын заалтыг үзүүрслэн ус ашиглаулах дүгнэлтээр тогтоосон төлбөрийн хувь хэмжээгээр орлогыг дараа сарын 10-ны өдрийн дотор төлж барагдуулна.

Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1. Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.2. Ус ашиглач нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Усны тухай хуулийн 17.1.9, 20.3 дугаар заалтуудыг үндэслэн Сав газрын захиргааны шийдвэрээр гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах бөгөөд Усны тухай хуулийн 33.1.10, 33.1.12, 33.1.13, 33.1.14, 33.1.15, 33.1.16 дахь заалтын дагуу хариуцлага хүлээнэ.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглаулах дүгнэлт ус ашиглах зэвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.


4.3. Ус ашиглаулагч нь 2017 оны 12 дугаар сарын 20-ны дотор ус ашиглалтын тайлант хүлээн авч, 2 тал гэрээний биелэлтийг ажлын 10 хоногт багтаан дүгнэж, тэмдэглэл үйлдэх гарын үсэг зурж баталгаажуулна.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба оөрчлөлтийг бингэр үйлдэнэ.

4.5. Талуудын хооронд үүссэн маргааныг зөвшилцэлийн журмаар шийдвэрлэхийг архэмлэх бөгөөд гарээ болон түүний аль нэг заалттай холбоотой асуудлаар зөвшилцэлд хурч чадаагүй тохиолдолд асуудлыг холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:


ТУУЛ ГОЛЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААГ
ТӨЛӨӨЛЖ:

Ус ашиглалтыг зохицуулах албаны
дарга  /Ю.Сувдчимэг/

Ус ашиглалтыг зохицуулах албаны уул
үүрхай, эрчим хүчиний ус ашиглалт
хариусан тахлах маржилтэн
 /С.Сүхбат/

"БАЯНГОЛ ЭКО ЗААМАР" ХХК-ИЙГ
ТӨЛӨӨЛЖ

Захирал

 /Г.Баянжаргал/

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй
дүүргийн 5-р хороо, "Оранж плаза"
төвийн 903 тоот
Харилцах утас: 99115544, 76115544,
99045702

Хаяг: Улаанбаатар хот-16050, БГД,
2-р хороо, Чингүнжавын гудамж,
Туул голын сав газрын захиргааны
байр, 2 дугаар давхар, 203 тоот өрөө
Харилцах утас: 363716, 363714, 362592